**“Операцын урлаг судлал” сэдэвт эрдэм шинжилгээ, онол аргазvйн хурал зохион байгуулагдлаа.**

“Монгол цэргийн одор”, шинэ vеийн зэвсэгт хvчин vvсгэн байгуулагдсаны 97 жилийн ойн баярыг угтсан “Операцын урлаг судлал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2018 оны 03 дугаар сарын 12-ны одор БХЯ, ЗХЖШ, ҮБХИС болон БХЭШХ хамтран 11 дэх жилдээ амжилттай зохион байгууллаа.

“Операцын урлаг судлал” сэдвийн хvрээнд зохион байгуулагдсан эрдэм шинжилгээ, онол аргазvйн хурлаар ЗХЖШ-ын удирдах бvрэлдэхvvн, БХЭШХ-ийн эрдэмтэн судлаачдын хамтарсан vндсэн нэг, туслах 7 илтгэлийг хэлэлцvvлсэн.

Хуралд Батлан хамгаалахын дэд сайд, БХЯ-ны ШУТЗ-ийн дарга Т.Дуламдорж, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Даваа нээж, баяр хvргэж vг хэллээ.